

# 10

## ТАТВАР ХУРААЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЭДИЙН ЗАСАГ, МАТЕМАТИК СТАТИСТИКИЙН АРГА АРГАЧЛАЛУУДЫГ АШИГЛАХ НЬ

С.Батцэцэг, Г.Оюунбилэг.

**Судалгааны ажлын зорилго:** Татвар хураалтын үйл ажиллагаанд эдийн засаг статистик- математик загварчлалын аргуудыг ашиглах чиглэлээр санал боловсруулах

**НЭГ. Татвар хураалтын үйл ажиллагааны өнөөгийн явц, төлөв**

**а. Татварын албаны зорилт, татвар хураалтын процедур**

1. ТЕГ, НТГ-ийн үйл ажиллагааны үндсэн чиглэлд тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлж татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих
2. Татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээг шуурхай болгох, сургалт сурталчилгааны ажлыг өргөтгөх
3. Тайлан хүлээн авалтын ирцийг сайжруулах стандарт хангах
4. Татвар хураалтын түвшинг дээшлүүлж, өр барагдуулах
- 5.
6. Улсын болон орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө биелүүлэх



**Татварын төлөвлөгөөний биелэлтийн явц:**



Татварын газар, хэлтэс тасгууд төлөвлөлтийг үндэслэлтэй хийж зохих дээд шатны байгууллагад танилцуулан батлуулдаг бол, мөн татварын хуулийн дагуу шат дараалсан арга хэмжээг хуулийн хугацаанд явуулж хэвшүүлвэл урьдчилгаа татвар төлүүлэхгүйгээр төлөвлөгөө биелэх боломжтой болно. Энэ нь татварын орлогод нөлөөлөх гадаад дотоод хүчин зүйлийн болон эдийн засгийн тогтворгүй байдал, инфляци зэрэг макро хүчин зүйлийн нөлөөллийг тооцож төлөвлөлтийг эконометрикийн судалгааны аргад тулгуурласан шинжилгээ хийж, төлөвлөлтийн загвар тэгшитгэл гарган ашиглах тулхэц болж байна.

**Татвар хураалтын үйл ажиллагаанд судалгаа шинжилгээ хийх шаардлага:**

1. Төсвийн төсөл боловсруулах хариуцлагыг анхан шатны нэгж сум, аймаг, дүүрэг, нийслэлийн татвар, улсын төсвийн орлого хяналтын газар, ТЕГ-т дээшлүүлж, зөвхөн урьд оны гүйцэтгэлийг үндэслэх бус, тухайн татварын байгууллагын үйл ажиллагааг сайтар мэдэж, судалсны үндсэн дээр төсвийн төлөвлөлтийн бодит байдлын түвшинг ахиулах,

2. Татварын газар, хэлтэс тасгууд татварын орлогын гүйцэтгэлд тогтмол дүн шинжилгээ хийж, төлөвлөгөөний биелэлтийг жил, улирал, сар тутам жигд ханган биелүүлэхийн тулд зөв үндэслэлтэй мэдээллээр хангагдаж байх,

3. Татварын орлогод нөлөөлөх статистик болон эдийн засгийн үзүүлэлтүүдийн тогтворгүй байдал, инфляци зэрэг макро хүчин зүйлүүд байнга өөрчлөгдөж байгаагаас урган гарч байна.

**Татвар хураалтын үйл ажиллагаанд судалгаа шинжилгээ хийх төлөвлөгөө:**

Агуулга	Төлөв байдлын шинжилгээ	Регрессийн шинжилгээ	Улирлын нөлөөлийн шинжилгээ
Үндсэн зорилго	Хан уул дүүргийн сүүлийн 6 жилийн үйл ажиллагааны үр дүнд шинжилгээ хийж төлөөлөх чадвар бүхий хувьсагчийг сонгох	Сонгосон хувьсагчдын корреляцийн коэффициентийг тодорхойлолж, прогнозын тэгшитгэлийн загвар томъёолох	Улирлын нөлөөлөлтэй эсэхийг тогтоох

Хувьсагчдын төлөв байдал	Хан уул дүүргийн Татварын хэлтсийн сүүлийн 6 жилийн төлөвлөгөөний биелэлт, татвар төлөгчийн тоо, татварт хамрагдалт, х тайлангийн тоо	Хан уул дүүргийн Татварын хэлтсийн татварын орлого, татварын ногдол,өрийн барагдалт, татварт хамрагдаагүй аан-ийн хувийн жингийн 2004 оны 01-ээс 2010 оны 02-р улирлын түүвэр үзүүлэлт, 2008-2010 оны инфляци	Хан уул дүүргийн Татварын хэлтсийн сүүлийн 6 жилийн төлөвлөгөөний биелэлт улирлаар, гүйцэтгэлийн өсөлтийн хурд,
Ерөнхий хэлбэр маяг	Санхүүгийн үр дүнгийн динамик болон харьцуулсан шинжилгээ	Нэг тэгшитгэл бүхий регрессийн загварын удирдан хувьсагч буюу У-г нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийн нөлөөллийг илэрхийлэх шинжилгээ хийх /хсс шугаман хамаарлын регрессийн тэгшитгэл/	Хугацааны цувааны загвараар төлөвлөгөөний биелэлтийн улирлын хэлбэлзлийг харуулах / Холт-Вентерсийн 2-р загвар/
Ашигласан программ хангамж	Tax payment, Tax account, Remainder, Plan, Burtgel, Economic returns	TTax payment, Tax account, Remainder, Plan , Burtgel, Economic returns . E-views 5.0,	Tax payment, Tax account, Remainder, Plan програмуудаас улирлын үр дүнгээр E-views 5.0


**б. Төлөв байдлын шинжилгээ**

**Нэгдүгээр хэсэг: Статистик үзүүлэлтийн судалгаа**

Татвар төлөгчийн тоо, тайлан өгсөн ААН-ийн тоо, х тайлангийн тоо, татварт хамрагдалтын хувь, тайлангийн ирцийн хувь гэсэн статистик үзүүлэлтүүдийг Хан уул дүүргийн Татварын хэлтсийн сүүлийн 6 жилийн баазаас түүвэрлэн динамик шинжилгээ хийж үзье.


он	нийт ттг	ААНОАГ-ын тайлан өгсөн	Тайлан-гийн ирц	Х тайлан	ААН-ийн тооны өсөлтийн хурд /өмнөх он/	тайлангийн өсөлтийн хурд/өмнөх он/	Тайлангийн ирцийн өсөлтийн хурд/өмнөх он/	Татварт хамрагдалтын хувь
2004	2011	1235	91.48	369				78.5
2005	2371	1428	90.67	464	117.9	125.7	115.6	67.4
2006	2790	1622	88.49	624	117.7	134.5	113.6	54.8
2007	2996	2062	90.36	831	107.4	133.2	127.1	70.6
2008	3745	2559	90.17	1159	125.0	139.5	124.1	70.1
2009	4260	2898	90.9	1250	113.8	107.9	113.2	70.1

Татвар төлөгчдийн тоо 2004-2007 онуудад 300 орчим ААНБ-аар буюу жилд дунджаар 7.4-17.4.0%-иар , 2008-2010 онуудад 500-800 орчим ААНБ-аар буюу 13.8-25.0% нэмэгдсэн байгаа нь ХУД-ийн нутаг дэвсгэрт томоохон ажлын байрууд, орон сууцны хороололууд баригдаж үүнтэй холбогдон эдийн засгийн идэвхитэй хүн амын тоо нэмэгдэж байгааг харуулж байна.




Татвар төлөгчийн тоо өсөхийн хэрээр тайлангийн ирц харилцан хамааралтай өсч ирсэн боловч Х тайлангийн тооны өсөлт 2009 оноос бусад онуудад тайлангийн ирцээс 10.1-21.8%-иар илүү өсөлттэй байгаа нь ААН-д нэмэгдэж байгаа боловч үйл ажиллагаа явуулдаггүй ААН нэмэгдэж байгааг харуулж байна. Гэвч 2009 он, 2010 онуудад х тайлангийн эзлэх хувийн жин багасах хандлага харагдаж байгаа нь сайшаалтай. Мөн татвар төлөгчийн тоо өсч байгаатай шууд хамааралтайгаар татварт хамрагдаагүй ААН-ийн тоо өсч байна. 2004 онд нийт ААНОАТ- төлөгчдийн 78.5% татварт хамрагдаж байсан бол 2007-2009 онуудад 70%-ийг эзлэх болсон байна.

**Хоёрдугаар хэсэг: Эдийн засгийн үзүүлэлтийн судалгаа**



Нийт татварын орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл 2007, 2009 онуудад 0.5-16.5%-иар тасарч, бусад онуудад 104.9-121.8%-иар биелсэн байна.



Он	Нийт орлого	Өсөлт /өмнөх онтой /	Өсөлтийн хурд /хэлхээ/	Өсөлт /суурь онтой 2005 /	Өсөлтийн хурд /суурь он 2005 хэлхээ/
2004	6651659.3				
2005	7197982.2	546322.9	8.2		
2006	10812218.9	3614236.7	50.2	3614236.7	50.2
2007	11069962.3	257743.4	2.4	3871980.1	53.8
2008	18284586.3	7214624.0	65.2	11086604.1	154.0
2009	26847132.8	8562546.5	46.8	19649150.6	273.0

**Татварын орлогын өсөлтийн шалтгаан:**



Татварын орлогын гүйцэтгэл нь 2005 онтой харьцуулахад 50.2-273%-иар буюу 3614.2 сая төгрөгнөөс 19649.2 сая төгрөгөөр нэмэгдсэн, өмнөх онтой нь

харьцуулахад 2.4-65.2 хувийн хурдтай буюу 257.7 сая төгрөгөөс 8562.5 сая төгрөгөөр нэмэгдэж иржээ.

**Татвар орлогод нөлөөлөх хүчин зүйлийн удирдан хувьсагчдыг сонгох**



**Хоёр.Татвар хураалтын үйл ажиллагаанд эконометрикийн аргачлалууд ашиглах нь**

**а. Эконометрикийн шинжилгээний онолын үндэс**

Шинжилгээ болон прогноз хийхэд үндсэн 3 төрлийн загвар ашиглана. Татварын орлогын төлөвлөгөөний биелэлтэнд нөлөөлөх хүчин зүйлүүдийн төлөөлөл болгон 5 удирдан хувьсагчийг сонгосон, мөн эдгээр хүчин зүйлүүд нь шугаман графикаар илэрхийлэгдэж байгаа тул хамгийн тохиромжтой загвар болох Нэг тэгшитгэл бүхий регрессийн загварыг сонгон авлаа.

**б. Татвар хураалтын үйл ажиллагаанд нөлөөлөх гадаад, дотоод хувьсагчийн коррелляцын болон регрессийн шинжилгээ**

Олон хүчин зүйлийн шугаман хэлбэрийн регрессийн тэгшитгэлээр удирдан хувьсагч болох татварын орлого буюу У-т нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийн нөлөөллийг илэрхийлэх корреляцийн хамаарлыг олъё. Үүнд: Хан уул дүүргийн Татварын хэлтсийн сүүлийн 26 улирлын нийт ААН-ийн тоо, өрийн барагдуулалт, татварын нийт ногдол, мөн хугацааны татвар төлөөгүй ААН-ийн нийт ААН-д эзлэх хувийн жин, сүүлийн 16 улирлын инфляцийг нөлөөлөлийн хүчин зүйлүүд болгон авлаа.

- У - Татварын орлого
- Х1- Татварын ногдол
- Х2- Татвар төлөгчийн тоо
- Х3-Татварын өрийн барагдуулалт
- Х4-Инфляци
- Х5-Татварт хамрагдаагүй ААН-ийн хувийн жин

Корреляцийн коэффициентийн шинжилгээ


	Y	X1	X2	X3	X4	X5
Y	1.0	0.80	0.86	0.37	-0.32	-0.40
X1	0.80	1.00	0.70	-0.14	-0.28	-0.58
X2	0.86	0.70	1.0	0.43	-0.13	-0.31
X3	0.37	-0.14	0.43	1.00	0.08	0.45
X4	-0.32	-0.28	-0.13	0.08	1.00	0.3
X5	-0.40	-0.58	-0.31	0.45	0.36	1.00

- Дээрхи тооцооллоос харахад:
- X1 –ийн  $R = 0.80 = 80\%$  X2 ийн  $R = 0.86 = 86\%$
- X3 ийн  $R = 0.37 = 37\%$  X4 ийн  $R = -0.32 = -32\%$  X5 ийн  $R = -0.40 = -40\%$  -тай гарч хамаарлын нөлөөлөл нь өндөр байгаа тул хэтийн төлөвлөлтөнд ашиглах боломжтой гэж үзэж байна.
- **Статистик үзүүлэлтүүд:**

	Y	X1	X2	X3	X4	X5
Mean	3714932.	3919794.	3031.769	790920.4	0.631250	50.79500
Median	2821628.	2723396.	2960.500	340298.8	0.400000	52.65000
Maximum	9711792.	14206307	4692.000	3213403.	2.800000	76.60000
Minimum	1284946.	1158410.	1821.000	42900.81	-1.200000	21.50000
Std. Dev.	2294390.	3215855.	871.8471	916280.4	1.249917	14.76189
Skewness	1.039126	2.019426	0.306852	1.276906	0.407587	-0.235541
Kurtosis	3.067464	6.280293	1.907586	3.581763	1.971739	2.084980
Jarque-Bera	4.683987	29.32871	1.700835	7.432107	1.147887	1.147444
Probability	0.086136	0.000000	0.427237	0.024330	0.563300	0.563425
Sum	96588227	1.02E+08	78826.00	20563930	10.10000	1320.670
Sum Sq. Dev.	1.32E+14	2.59E+14	19002935	2.10E+13	23.43437	5447.832
Observations	26	26	26	26	16	26

E-views-5.0 программаар үзүүлэлтийн харилцан хамаарлыг графикаар харахад:





E-views-5.0 программаар хамгийн бага квадратын аргаар Татварын орлогыг үнэлэхэд:

Dependent Variable: Y				
Method: Least Squares				
Date: 10/04/10 Time: 22:42				
Sample(adjusted): 2006:1 2009:4				
Included observations: 16 after adjusting endpoints				
Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
C	-1423521.	1535311.	-0.927187	0.3757
X1	0.416047	0.117081	3.553490	0.0052
X2	1307.998	492.1582	2.657678	0.0240
X3	0.636726	0.229704	2.771939	0.0197
X4	-203140.5	109184.6	-1.860524	0.0924
X5	-13205.92	12465.49	-1.059398	0.3143
R-squared	0.957955	Mean dependent var		4188369.
Adjusted R-squared	0.936933	S.D. dependent var		1909993.
S.E. of regression	479660.4	Akaike info criterion		29.27954
Sum squared resid	2.30E+12	Schwarz criterion		29.56926
Log likelihood	-228.2363	F-statistic		45.56824
Durbin-Watson stat	2.061815	Prob(F-statistic)		0.000001

Эндээс харахад сонгосон хүчин зүйлүүдийн тайлбарлах чадвар нь /R-squared / 95 % байгаа нь төлөөлөх чадвартайг илтгэж байгаа бөгөөд хамаарлын хүч нь 0.93 буюу корреляцийн коэффициент нь 93.6% байна.

Durbin-Watson stat нь /0-4байдаг/ 2.06 гарсан нь судалгааны үр дүн бодитой гэдгийг харуулж байна.Гэвч энэхүү регрессийн тэгшитгэлийн тооцооллын алдаа нь 479660.4 аас язгуур гаргаж 692.572 мян.төгрөг байна. Дээрхи үзүүлэлтүүд тус бүрийн алдааны магадлал нь 0.0054-0.3143 хүртэл байгаа /0-тэй дөхөх тусам алдааны магадлал бага байдаг./ тул татварын орлогын загвар тэгшитгэл гарган дараахь улирал, жилийн прогнозыг хийж үзье.

**Татварын орлогын прогнозын загвар тэгшитгэл:**

$$Y = -1423521 + 0.416047 * X1 + 1307.998 * X2 + 0.636726 * X3 - 203140.5 * X4 - 13205.92 * X5$$

**Тэгшитгэлийн шууд хамааралтай үзүүлэлт:**



X1 - татварын ногдол/ 1 нэгжээр буюу 1 сая төгрөгөөр нэмэгдэхэд 0.416 мян.төгрөгийн,

X2 - татвар төлөгчийн тоо/ 1 нэгжээр нэмэгдэхэд 1308.0 мян.төгрөгийн,

X3 - өрийн барагдуулалт/ 1 нэгжээр нэмэгдэхэд 0.636726 мян.төгрөгийн өсөлттэй нэмэгдэнэ.

**Тэгшитгэлийн урвуу хамааралтай үзүүлэлт:**

X4 - инфляци/ 1 нэгжээр нэмэгдэхэд 203140.5 мян.төгрөгөөр ,

X5 - татварт хамрагдаагүй аан-ийн эзлэх хувийн жин/ 1 хувиар нэмэгдэхэд 13205.9 мян.төгрөгөөр буурна.


**Дээрхи тэгшитгэлийг ашиглан 2010 оны 1, 2,3 –р улирлын татварын орлогын дүнтэй харьцуулсан тооцоолол, ирэх 4-р улирлын орлогын прогноз тооцооллыг доорхи хүснэгтээр харууллаа.**

	X1	X2	X3	X4	X5
Хугацаа	Ногдол	ТТТ	Өрийн барагдуулалт	Инфляци	Татварт хамрагдалт
2010.03-р улирал	14206306.8	4692	1695794.60	0.12	35
2010.04-р улирал	15484874.4	4830	2254228.0	0.12	30
2010.01-р улирал	8895689.76	4260	209991.00	0.2	75.23
2010.02-р улирал	11181748.5	4472	2254228.00	0.2	68.83
Шалгасан нь:					
Хугацаа	Тэгшилгэлийн прогноз	Гийцэтгэл	Алдааны магадлал, % зөрї		
2010.01-р улирал	6949173	6060166.9	14.67%	889006.1	
2010.02-р улирал	9655011.89	9916729.4	2.64%	261717.5	
2010.03-р улирал	11217269.39	10079411.6	11.3%	1137858	
Прогноз:					
Прогноз:	їр дїн	Гийцэтгэл	Алдааны магадлал % зөрї		
2010.04-р улирал	12351316				

**в/ Татварын төлөвлөгөө, гүйцэтгэлийн улирлын нөлөөллийн судалгаа**

- Улирлын нөлөөллийн хэлбэлзлийг хугацааны цувааны загвар болох шаталсан дунджын аргаар судалгаа хийж үзье.

	2004	2005	2006	2007	2008	2009	їāāēāī	Ōēēōēūī ēīāāēñ
1-улирал		0.852	0.83	0.954	0.774	0.903	0.852	85.6
2-улирал		0.993	1.159	0.835	1.07	1.026	1.026	103.1
3-улирал	0.911	1.008	0.947	1.045	0.942	0.982	0.9645	96.9
4-улирал	1.25	0.982	1.188	1.045	1.168	1.111	1.1395	114.5
							3.982	400.0



Холтс- Винтерсийн 2-р загвар нь:

$$\hat{x}_{t+h} = (\bar{x}_t + h * T_t) * F_t$$

Ємнєх улирлын үнэлсэн утга /mean/, дараалал, trend буюу есєлт илэрхийлэх коэффициент, улирлын нєлєєлєл

Date: 09/29/10 Time: 14:35  
 Sample: 2004:1 2010:2  
 Included observations: 26  
 Method: Holt-Winters Multiplicative Seasonal  
 Original Series: Y  
 Forecast Series: YSM

Parameters:			
	Alpha		0.6400
	Beta		0.2000
	Gamma		0.4201
Sum of Squared Residuals			1.07E+13
Root Mean Squared Error			641163.2
End of Period Levels:			
	Mean		8688022.
	Trend		568017.8
	Seasonals:	2009:3	0.974037
		2009:4	1.104427
		2010:1	0.888046
		2010:2	1.033490

- Улирлын нөлөөлөл тооцсон прогноз

Шалгасан нь:	Улирлын нөлөөлөл тооцсон дүн	Гийцэтгэл	Алдааны магадлал /%-иар/	зерїї	
2010.01-р улирал	5948492.1	6060166.9	1.84%	111674.8	
2010.02-р улирал	9954317.2	9916729.4	0.38%	37587.8	
2010.03-р улирал	10869534	10079411.6	7.27%	790122.4	
<b>Прогноз:</b>	Улирлын нөлөөлөл тооцсон дүн	<b>Гийцэтгэл</b>	Алдааны магадлал /%-иар/	зерїї	
2010.04-р улирал	12351316				

Өмнөх тооцоололд ашигласан судалгаанд үндэслэн 4-р улирлын татварт төвлөрөх орлогын боломжийг сараар тодорхойлвол:

Сар	Прогноз /сая төгрөгөөр/	Гүйцэтгэл /сая төгрөгөөр/	Тооцолсон боломж /сая төгрөгөөр/
7	4197.2	3234.1	
8	2948.2	2954.7	
9	4071.8	3890.7	
10	4360.8	4584.9	5102.0
11	3186.6	3079.6	
12	4803.9	-	

### 3. Татварт төвлөгөө биелэх боломжийн судалгаа



### 2010 оны 10 сарын төвлөгөө биелүүлэх боломжийн судалгаа

ТӨРӨЛ	Тухайн сарын нийт			Тухайн сард орох боломж	Хилээгдэж буй гүйцэтгэл	Хувиар
	төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөөний биелэлт /хувь/			
ААНОАТ	311,151.60	50,658.40	16%	736,219.60	786,878.00	253%
НӨАТ	1,405,186.50	721,206.60	51%	1,815,710.00	2,536,916.60	181%
ОНЦГОЙ	91,175.00		0%	167,095.70	167,095.70	183%
АПТ	575,000.00	50,000.00	9%	-	50,000.00	9%
<b>ТӨВЛӨРСӨН</b>	<b>2,382,513.10</b>	<b>821,865.00</b>	<b>34%</b>	<b>2,719,025.30</b>	<b>3,540,890.30</b>	<b>149%</b>
СУУТГАН	893,138.10	239,105.70	24%	404,305.70	643,411.40	65%
Суутгагчийн хувь хинд олгосон албан татвар	71,874.20	26,664.30	37%	47,006.60	73,670.90	102%
Бууны татвар	255.20	166.00	65%	848.00	1,014.00	397%
Улсын тэмдэгтийн хураамж	271,586.80	2,251.90	1%	-	2,251.90	1%
Ус, рэвцгаан ашигласны төлбөр	184.40		0%	-	-	0%
Хүү торгуулийн орлого	47,695.70	20,886.30	44%	117,070.50	137,956.80	289%
Бусад орлого	38,227.80	137,372.60	359%	995.40	138,368.00	362%
ҮХЭХАТ	130,786.20	29,061.70	22%	495,594.90	524,656.60	401%
АТБӨЯХАТ	2,046.90	1,603.00	78%	13,484.10	15,087.10	737%
Аж ахуй эрхэлсний орлого	137,168.70	23,193.10	17%	1,463.40	24,656.50	18%
<b>ОРОН НУТАГ</b>	<b>1,692,964.00</b>	<b>480,304.60</b>	<b>28%</b>	<b>1,080,768.60</b>	<b>1,561,073.20</b>	<b>92%</b>
<b>НИЙТ ДҮН</b>	<b>4,075,477.10</b>	<b>1,302,169.60</b>	<b>32%</b>	<b>3,799,793.90</b>	<b>5,101,963.50</b>	<b>125%</b>

**Дүгнэлт:**

1. Татварын төлөвлөлт, гүйцэтгэлийн уялдаа доголдолтой, сар, улирал, жилээр судалгаа шинжилгээг тогтмол хийж цаашид үндэслэлтэй тооцоололд хийсэн төлөвлөлтийг дээд байгууллагаар батлуулан мөрдөж ажиллах шаардлагатай байгаа нь харагдаж байна.
2. Татварын орлогод нөлөөлөх удирдан хувьсагчидын нөлөөлөлийн магадлал 90.0%-иас дээш гарч байгаа нь эконометрикийн шинжилгээг татвар хураалтын үйл ажиллагаанд ашиглан шинжилгээ хийх боломжтойг харуулж байгаа бөгөөд өмнөх улирлын гүйцэтгэлд үндэслэсэн шалгуураас харахад улирлын нөлөөлөл болон бусад хувьсагчдын нөлөөллийг тооцох шаардлагатайг харуулж байна.
3. Татварын орлогод улирлын нөлөөлөл өндөр гарч байгааг харуулж байгаа бөгөөд улирлын гүйцэтгэлийг төлөвлөлтөнд нэг үзүүлэлт болгон ашиглах нь үр дүнтэй нь харагдаж байна
4. Энэ процедурыг программд шилжүүлснээр татварын орлого төвлөрөх боломж нь байцаагч бүрээр стандарт хангаж буй эсэх нь харагдах ба удирдлага болон байцаагчдыг мэдээллээр хангаж хуулийн хэрэгжилтийг сайжруулах түлхэц болно.

**Санал:**

1. Бодит байдалд сайн тохирсон эконометрик загварчлалын системийг төлөвлөлттэй уялдуулах буюу прогнозоллын нэгдсэн аргачлалыг боловсруулах
2. Эконометрикийн шинэжилгээний загварыг Татварын газар, хэлтэс, дүүргийн байцаагчдын ажлыг дүгнэх стандарттай холбох, нэгдсэн аргачлалтай болох
3. Татварын төлөвлөгөөний биелэлтэнд нөлөөлж буй эрсдлийг тооцож, ТУБ хариуцсан ААН-ийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж эрсдэлийн мэдээллийг программд оруулдаг болох
4. Татварын газар хэлтэс тасгуудын эдийн засагч нарыг эконометрикийн судалгаа, шинжилгээний чиглэлээр мэргэшүүлэх
5. ТЕГ, НТГ-ын хэмжээгээр статистик мэдээ судалгааны ном товхимол жилд 1 удаа гаргаж байх